



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/593

Арвайхээр

Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 258 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх аж ахуй нэгж, иргэнийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай

2. Аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцийн өвс, тэжээлийг хүлээн авах, хадгалалт хамгаалалт, зарцуулалтыг хариуцан ажиллахыг Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Т.Мөнхдорж)-т даалгасугай.

3. Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг өвс, тэжээл бүрдүүлсэний орлогоос гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Аймаг сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд өвс, тэжээлийн чанар (нойтон, илжирч муудсан, жил өнжсөн), баглаа боодолд, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101089